



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/192

Булган сум

Мах нийлүүлэх ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зарцуулах журам”-ын 2.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.4.1.4, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар “Булган аймгийн төсөв батлах тухай” тогтоолын 3.2.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2025 оны А/83 дугаар захирамжаар байгуулагдсан “Мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг”-ийн шийдвэрийн дагуу Булган сумын хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд чанар, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан Үхрийн махыг-12500 төгрөг, Хонины махыг-10500 төгрөг, Ямааны махыг-8500 төгрөгөөр нийт 10 тн мах бэлтгэн нийлүүлэх гэрээг “Эрдмийт” ХХК-тай байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг)-д үүрэг болгосугай.

2. Бэлтгэн нийлүүлж байгаа махны чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Худалдаанд нийлүүлж байгаа махны өдөр тутмын гүйцэтгэлд хяналт тавьж, тооцоо нийлж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал), явцын болон гүйцэтгэлийн хяналтыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

4. Гэрээний дагуу бэлтгэн нийлүүлсэн 1 кг мах тутамд 2300 (хоёр мянга гурван зуу) төгрөгийн урамшууллыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоол “Булган аймгийн төсөв батлах тухай”-ын 3.2.20 дахь заалтад тусгагдсан зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010323